

САНЖААЖАМЦ, БЬЮЗАН НАРЫН ЗУРАГ ЗУРАХ СЭТГЭЛГЭЭ

Д.Цэдэн-Иш, дэд профессор, МУБИС

Abstract: It impossible to concern with the human mind separately from the development of human race. And the development of mind exists as the result of human's marvelous brain development. There exists the information sting that presently there are studying this over 120 researchers over the world. One of them is Tony Buzan of the Great Britain. Representing the method of Mind Mapping of T.Buzan and the artistic creations of Mknngolian artists D. Sanjaajamrs made comparison between the drawing method and the mind to draw. Also it is concerned with the research on developments of left and right brains of Mongolian children.

Түлхүүр үг: Оюун ухаан, хүний уураг тархи, цацаргах сэтгэлгээ, оюуны зураглал

Удиртгал

Олон улсын эрдэмтдийн судалгаагаар хүний тархины хүчин чадлын боломж таамаглаж байгаагаас хавьгүй илүү гэдгийг тогтоогоод байна. Эрдэмтэн Т.Бьюзан, Б. Бьюзан нар “Хүн тархиныхаа боломжийн зөвхөн нэг хувийг л ашигладаг гэсэн түгээмэл ойлголт худал болж, бид нэгээс ч бага хувийг л ашиглаж байна” Т.Бьюзан (2005).6 гэж тодорхойлсон байдаг. Америкийн эрдэмтэн Р.Орнстейн зэрэг олон судлаач хүний зүүн тал тархи нь: Математик, хэл, логик, дүн шинжилгээ зэргийг, баруун тал тархи нь: Зураг дүрслэл, өнгө, хөгжим хэмнэл, харьцуулан шинжлэл зэргийг тус тус удирддаг болохыг тогтоожээ.

Сэдвийн онол арга зүйн үндэс

Хүний тархины бор гадаргад дунджаар зуун тэрбум нервийн эс бий. Нервийн эсүүдийн холбоос (санах ул мөр) хэдий чинээ олон буюу бат бөх байх эсэх нь тухайн хүний сэтгэлгээний хурдаас хамаарна. Зөвхөн нэг эс гэхэд маш богино хугацаанд арван мянга орчим эстэй орооцолдон холбогдож чаддаг. Энэ холбоос нь хүний ухааны зүйрлэшгүй дүр зураг, хэмжээлшгүй хэв загварыг бий болгон хөгжүүлэх эх булаг болдог байна.


1973 онд Москвагийн их сургуулийн профессор Петр Кузмич Анохин хүний нервийн мөн чанарын талаар “Заяагдмал болон хиймэл оюун ухаан бүрэлдэхүй” бүтээлдээ:

“Хүний нервийн зөвхөн нэг эсийн бусад эстэй синаптик холбоос үүсгэх боломж нь нэг тэгийн ард хорин найман ширхэг тэг байх тоотой тэнцүү байна. Харин үүнийг нийт эсийн хэмжээнд авч тооцвол эсүүдийн синаптик холбоос үүсгэх боломж нь нэгийн ард 10.5 сая км урт үргэлжлэх тэгийн цуваа үүсгэх болно” гэж тодорхойлсон.

Цацаргах сэтгэлгээ

Хүний уураг тархины ойлгон хүлээн авах, хадгалах, сэргээн санах, үйл явц дахь чухал үе шат бол цацаргах сэтгэлгээ юм. Цацаргах сэтгэлгээ нь оюуны холбох чадварыг хөгжүүлдэг бөгөөд тухайн хүний оюуны дахин үл давтагдах онцлогийг илэрхийлдэг. Суралцагчид мэдлэг бүтээх тусам тэдний оюуны холбох чадвар төдий чинээ өсч хөгжинө.

Суут ухаантнууд оюуны төрөлх чадвараа бүрэн дүүрэн ашиглаж чаддаг, цацаргах сэтгэлгээгээ зөнгөөрөө хөгжүүлдэг байжээ. Хүний уураг тархины хүлээн авах мэдээллийн нэгж бүрийг бүрдүүлэх аливаа зүйлс, ой тогтоолт, сэтгэлгээ (зурах, будах, дүрс таних гэх мэт) зэрэг нь бөмбөрцгийн төвөөс тал бүр тийш цацран түгэх хэдэн арав, мянга, сая дэгээ мэт дүрслэгдсэн байдаг. Дэгээ бүр нь холбоостой, холбоос бүр нь өөрийн төгсөшгүй тооны зангилааны үзүүрээс бүрдсэн байна. Энэхүү үлэмж тооны дэгээрч гогцоорсон олон чигт цацарсан мэдээлэл боловсруулах, хадгалах тогтолцоог ашигласны үр дүнд хүний уураг тархи мэдээллийн дуусашгүй зураг схемийг өөртөө бүрдүүлээд, дундаршгүй их хадгаламжийн сантай болчихсон байдаг.



Уураг тархинд мэдээллийн ганц “Нэгж” л ийнхүү цацран тархдаг байна. [1.х74]


Профессор Анохины энэхүү “Тайхамшигт хадгаламжийн сан” нь уураг тархи урьд нь боловсруулж байсан өгөгдлөө дахин ашиглах замаар хэрхэн цоо шинэ хэв загвар бүтээн бий болгох чадвараас ихээхэн шалтгаалдаг гэж үздэг. Санах ойд хадгалагдсан мэдээлэл хэдий чинээ сайн байх тусам уураг тархины гоц мэргэн санаа олох, шинэ хэв загвар бий болгох чадвар ихээхэн эрчимждэг байна.

Ерөнхий судалгаа нэг. Зураг зурах сэтгэлгээ (харьцуулалт)

Тони Бьюзан

Тони Бьюзан хүний уураг тархины мэдээлэл боловсруулах онцгой чадвар болон суралцахуйн нөөц боломжид үндэслэн цацаргах сэтгэлгээ түүний илэрхийлэл болсон “Оюуны зураглал”-ын үзэл баримтлалаа боловсруулсан байна. Цацаргах сэтгэлгээ гэдэг нь аливаа зүйлийг оюуныхаа төв цэг болгож аваад, түүнээс гэрэл цацрах мэт тал тал тийш цацарган сэтгэх үйл явцыг хэлдэг.

Зураг, дүрслэлээр цацаргах



Нервийн эсийн холбоост зам нь санах ойд ул мөрөө үлдээж түүгээр танигдана.

Т.Бьюзан Оюуны зураглал номондоо: “Оюуны зураглал бол цацаргах сэтгэлгээний толь юм. Оюуны зураглал нь ямагт төв дүрснээс цацарсан байна. Зураглалын цацрагууд дээрх үгс, дүрс зураг бүр нь төв цэгээс салбарлан цацрах төгсөшгүй гинжин цувааг буй болгодог”. Т.Бьюзан (2005).78 гэж тэмдэглэжээ.

Д.Санжаажамц


“Нүүх үү” зурагт Монгол зан заншил, ахуй амьдрал, оюун санааг илэрхийлсэн байна. Зураг дээр хүүхэд хөтөлсөн хүн хайнагийн шар тууж явна. Хайнагийн нуруун дээр гурван гэр байна.

Бид “Оюуны зураглал” зурахдаа гол дүрээс цацрагууд гарган түүн дээр зураг зурж, үг бичдэг.


Нервийн эсүүдийн холбоос (санах ул мөр) хэдий чинээ олон буюу бат бөх байх эсэх нь тухайн хүний сэтгэлгээний хурдаас хамаарна. Санжаажамцын зурсан энэ зурагт хүн, хайнагийн шар, нохой, гэр, модон тэрэг бүгд холбоотой зурагджээ. Зурагт чандмань эрдэнэ мэт байрлалаар буусан гурван айл байна. Энэ нь “Эцэг эхдээ эрдэнэ” болсон хүүхдүүд нь өсөж гурван айл болсон санаа илэрхийлнэ.



Зүүн тал бөмбөлөг – шугаман сэтгэлгээ голлодог.



Баруун тал бөмбөлөг – цацаргах сэтгэлгээ давамгайлна



Баруун тал бөмбөлөг

Зураг дүрслэл, өнгө хэмнэл, орон зайн мэдрэхүйг бүхэлд нь нэгтгэн дүгнэх зэргийг хариуцна.

Сайн тал нь: Бодит дүрслэлийн ойн үйл

ажиллагаа, орчлон ертөнцийн юмс, үзэгдлийг үлээн авах үүрэгтэй. Ухаан бодлыг гайхалтай хөгжүүлдэг. Хүний хүсэл мөрөөдөл, уран зөгнөл, ургуулан бодох, утга уянга, орон зайн мэдрэхүйг хөгжүүлэхэд онцгой үүрэгтэй. Мөн далд ухамсрыг ойлгоход үндсэн үүрэг гүйцэтгэнэ.

Сул тал нь: Юмыг ялган салгахдаа сайн боловч нарийн тооцоолох зүйлийг төдийлөн анхаардаггүй.

Зүүн тал бөмбөлөг:

Үг яриа, математик, логик, юмыг ялган салгах логик сэтгэлгээ зэргийг хариуцдаг.

Сайн тал нь: Шүүн тунгаах чадвар сайтай. Бүх юмсыг утга төгс ойлгохыг боддог. Хүмүүстэй харьцах, үгийн сүлжээ бөглөх, бодлого бодох зэрэгт илүү чадвартай. Логик сэтгэлгээ, шугаман дараалал, математик болон шинжлэх ухааны сэтгэлгээтэй холбоотой зүйлийг илүү хүртэж

чадна.

Сул тал: Цөөнгүй муу зуршилтай. Зан авирын хувьд алдаа гаргах нь их. Аливаа зүйлийг эргэцүүлэн бодох чадвар султай. Юмсын учир холбогдлыг тунгаахгүй цээжлэхийг чухалчилдаг.


Ерөнхий судалгаа хоёр. Монгол хүүхдийн тархины баруун зүүн тал бөмбөлгийн болон цацаргах сэтгэлгээний онцлогийг судлав.

Судалгаа 2.1

Судалгааны үр дүн:

Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн IV ангийн 10 настай сурагчдын баруун зүүн тал бөмбөлгийн хөгжих боломж судалгааг Г.Адлерийн тестээр судалгаа авч дүгнэхэд зүүн тал бөмбөлөг нь давуу хөгжих 125, баруун тал бөмбөлөг нь өндөр хөгжих боломжтой 185 сурагч байлаа.

Судалгаа 2.1



Сурагчдын зурах дүрслэх чадварыг хөгжүүлнэ гэдэг нь тэдний их тархины хоёр тал бөмбөлгийг тэнцвэртэй хөгжүүлэх асуудал юм.

Судалгаа 2.2

Судалгааны үр дүн:

Монголын 10, 12 настай хүүхдүүдийн их тархины зүүн баруун, тал бөмбөлгийн хөгжлийн талаар Г.Адлерийн тестээр судалгаа авч дүгнэв. Үүнд: Улаанбаатар хотын ерөнхий боловсролын 5, 15, 17, 24, 51 дүгээр сургууль болон Төв, Увс, Өмнөговь, Сүхбаатар аймгийн сургуулиудын 4, 5 дугаар ангийн сурагчид хамрагдав.

Судалгаа 2.2

Судалгаанд оролцогчдын тоо	Сургууль, анги	Нас	Зүүн тал бөмбөлгөө хөгжүүлэх боломж өндөр сурагчид	Баруун тал бөмбөлгөө хөгжүүлэх боломж өндөр сурагчид	Тархины хоёр тал бөмбөлгөө зэрэг хөгжүүлэх боломж өндөр сурагчид	Дүрслэх урлагийн хичээлийн сургалтын түвшин тогтоох шалгалтын үнэлгээ
115	IV анги (хотын)	10	70 (60.8%)	45 (39.1%)	41 (35.6%)	F үнэлгээ авсан сурагч 31
115	IV анги (хөдөө)	12	66 (57.3%)	49 (42.6%)	25 (21.7%)	F үнэлгээ авсан сурагч 42

Судалгааны үр дүн:

10 настай сурагчдын баруун тархи хөгжих боломж өндөр байгаа боловч дүрслэх урлагийн сургалтын түвшин тогтоох шалгалтын үнэлгээгээр ЕБ-ийн 12 жилийн хотын сургуулийн IV ангийн сурагчид 73.1% хөдөөгийн IV ангийн сурагчид 63.5 % үнэлэгдэв.

ДҮГНЭЛТ

- Уламжлал шинэчлэлийн зарчмыг бүтээлчээр хэрэгжүүлэх асуудал дүрслэх урлагийн боловсролын шинэчлэлийн чухал зорилтуудын нэг мөн.
- Монгол хүний цацаргах сэтгэлгээ давамгайлдаг бөгөөд үүнийг өндөр түвшинд хөгжүүлэх боломжтой.
- Монгол хүүхэд ерөнхийгөөс нэгжид чиглэсэн сэтгэлгээ давамгайлдаг.
- Сурагчдын зурах дүрслэх чадварыг хөгжүүлнэ гэдэг нь тэдний их тархины хоёр тал бөмбөлгийг тэнцвэртэй хөгжүүлэх асуудал юм.
- Орчин үеийн багш боловсролыг улам боловсронгуй болгохын тул сургалтын стандарт, хөтөлбөрийн прагматик чиглэлийг нэмэгдүүлж, олон улсын жишигт ойртуулах, өөрийн орны өвөрмөц онцлог болон судалгаа, шинжилгээнд тулгуурласан боловсролын шинэчлэл хийх шаардлагатай байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Батцэцэг, Н. (2010). *Хүний гэрлэн бүрхүүл*. Улаанбаатар
- Батчулуун, Л. (2003). *Эсгий урлаг, тэмдэгтийн тогтолцоо*. Улаанбаатар
- Бернштейн, Н. А. (1990). *Физиология движений и активность*. Москва.
- Бьюзан, Т. (2005). *Оюуны зураглал*. Орчуулсан Ш.Энх-Амар. Улаанбаатар
- Даваахүү, С. (2007). *Уураг тархи ба шинжлэх ухаан*. Улаанбаатар
- Дэлгэрмаа, Б. (2002). *Урлаг ба танин мэдэхүйн онолын харилцааны асуудал*. Улаанбаатар
- Жои, Эванс, Таня, Скелтон. (2009). *Дүрслэх урлаг*. Улаанбаатар
- Солсо, Р.Л. (1996). *Когнитивная психология*. Москва.
- Цойгнер, Г. (1971). *Учение о цвете*. Москва.
- Цэдэн-Иш, Д. (2007). *Сурагчдын зурах дүрслэх чадварын хөгжлийн судалгаа*. Улаанбаатар
- Цэдэн-Иш, Д. (2011). *Дүрслэх урлагийн багшийн ном*. Улаанбаатар
- Эрдэнэцог, Ц. (2007). *XX зууны Монголын уран зургийн өнгө зохирол*. Улаанбаатар

Оюуны хөтөч. 2012. №4